



АРХИВЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР

ᠠᠷᠬᠢᠶᠢᠨ ᠶᠡᠷᠦᠨᠬᠢᠢ
ᠭᠠᠰᠠᠷ

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ИЛДЭН ЗАСГИЙН ХОШУУНЫ ХҮН АМЫН ТООЛЛОГЫН БҮРТГЭЛ

АЕГ-ын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Б.Ринчинноров

1925 оны тооллогын баримтад

15 сумтайгаар бүртгэж 2 сумын нэрийг бичиж, бусад сумдын нэрийг бичээгүй байна. Нийт 2250 өрх бүртгэжээ.

Мөн арван гэр, баг, сумын дарга нарын нэрийг тодорхой бичсэн байна.

1926 оны баримт

ҮТА-ын Х-152. Д-2. ХН-8 “Цэцэрлэг мандлын аймгийн Өлзийт уулын хошууны хүн амын данс” гэх 271 хуудастай баримтын Нэгдүгээр сум Сант сумын нэгдүгээр багийн 5-р өрхөд Иринчинжугнайн хөвгүүн Норовжанцан ноёныхон байна.

Тооллогонд лам нарын нас, бусад эрчүүдийн насны бүлгийг 4 хувааж 1-7, 8-17, 18-45, 46 наснаас дээш, бичиг үсэг, гэрийн ажил, өвчин эмгэгтэй эсэхийг бүртгэжээ.

№	НЭР	Нас	бичиг	Юу хийдэг	Өвчин эмгэг
5	Иринчинжугнайн хөвгүүн Норовжанцан	16	Монгол бичиг		
	Хөвгүүн Цэрэндүн	15	Түвэд ном		
	Хөвгүүн Цэрэндүн	6		Үйл	
	Эх Цэрэндолгор	40			
	Дүү Дэнсмаа	12			
Монгол Улсын 15 /1925/ он 9 сарын 20					



1926 оны тооллогын баримтад

Сант, Дэлгэрэх, Авдран, Ханги, Өндөр, Сангийн далай, Цагаан, Ширээчулуу, Ёсөнзүйл, Өлзий, Оргих, Жаргалант, Гүндсамба сум, Лагшин сум, Төгс уул сум гэх нэртэй 15 сумтай байжээ.

Өрхийн дугаарыг сум сумаас нь шинээр эхлэн бүртгэсэн байна.

Мөн арван гэр, баг, сумын дарга нарын нэрийг тодорхой бичсэн байна.

1927 оны баримт

ҮТА-ын сан хөмрөгийн Х-152. Д-2. ХН-14-т “Цэцэрлэг мандлын аймгийн Өлзийт уулын хошууны хүн амын данс амой” нэртэйгээр 274 хуудас бүрэн гүйцэт баримтад Нэгдүгээр сумын 8-р өрхөд хошуу ноён асан Норовжанцангийн өрхийн бүртгэл байна.

Тооллогонд тайж, лам, хар хэмээн бичээгүй, лам нарын нас, насны бүлгийг 4 хувааж 1-7, 8-17, 18-45, 46 наснаас дээш, бичиг үсэг, гэрийн ажил, өвчин эмгэгтэй эсэхийг бүртгэжээ.

№	НЭР	Нас	бичиг	Юу хийдэг	Өвчин эмгэг
5	Иринчинжугнайн хөвгүүн Норовжанцан	17	Бичигт сайн		
	Мөн Цэрэндүн	16			
	Мөн Цэрэндүн	7		Үйл	
	Цэрэндолгор	41			
	Охин Дэнсмаа	13			
Монгол Улсын 17 /1927/ он 8 сарын 28					

1927 оны тооллогын баримтад

15 сумтайгаар бүртгэж сумдын нэрийг бичээгүй байна.

Өрхийн дугаарыг сум сумаас нь шинээр эхлэн бүртгэсэн байна.

Мөн арван гэр, баг, сумын дарга нарын нэрийг тодорхой бичсэн байна.

1929 оны баримт

Өлзийт уулын хошуу нь 1927 онд 12 сумтай байсан бол 1929 онд “Авдран, Дэлгэрэх, Өлзий, Есөнзүйл, Жаргалант, Оргих-Өндөр, Сант, Сангийн далай, Цагаан, Ширээчулуу” гэсэн 10 сумтай болжээ.

1929 оны тооллого тусгай маягтад бүртгэсэн байдаг. Тооллогод “Гэрийн эзнийг овог нэртэй бүртгээд бусад гишүүдийг гэргий, хүү охин, эцэг эх, ах дүү, ач зээ, хүргэн бэрээр нь ялган бүртгэхээс гадна өвчин эмгэг, мөн эд хөрөнгө, таван зүйл малын тоог маш нарийн бүртгэсэн чухал тооллого билээ.

Норовжанцан ноёныг хайж үзвэл ҮТА-ын Х-152. Д-2. ХН-31 тоот баримтын 623-р талд Хуримт нуурын сумын 15-р хоринд Иринчинжугнайн Норовжанцан нэрээр байх ажээ.

Сант сумын 15 хорин

ОВОГ	нэр	хүйс	нас	юу
Иринчинжугнай	Норовжанцан	Эр	19	Өрхийн тэргүүн
	Цэрэндүн	Эр	18	Дүү
	Цэрэндүн	Эр	9	Дүү
	Цэрэндолгор	Эм	43	Эх
	Дэнсмаа	Эм	14	Дүү

Дүгнэлт

Нэг: 1691-1922 он хүртэл Сайн ноён /хан/ аймгийн Илдэн засгийн хошуу, 1923-1931 онд Цэцэрлэг мандлын аймгийн Өлзийт уулын хошуу болсон энэ хошууны нутаг нь өнөөгийн байдлаар Өвөрхангай аймгийн Хужирт, Зүйл, Сант, Өлзийт сумын нутаг багтах ажээ.

Хоёр: Норовжанцан ноёныхон 1922-1929 онд Өлзийт уулын хошууны нэгдүгээр Сант сумын харьяат байв.

Гурав: Зарим хүмүүс манай өвөг дээдэс тооллогын баримтанд байхгүй байна гэх нь нилээдгүй байдаг нь сумдын нэрийг энэ мэтээр өөрчлөн зохион байгуулдаг байсантай холбоотой. Мөн өөр аймаг, хошууны нутагт оршин суугаа айл өрхийг тэр хошуунд нь тоолдог байсан тохиолдол нилээдгүй байв.

Тооллого бүртгэлтэй ном хэвлэгдэн гарахад зарим нэг нэр болон нас нь зөрөөтэй гарах аваас буруу буулгасан бус эх бүртгэлд ийм буйг анхаарах хэрэгтэй.



АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА

ЦАХИМ
ХУУДАС



www.
ARCHIVES.GOV.MN

SOCIAL
NETWORK

[www.facebook.com/](http://www.facebook.com/ArchivesofMongolia)
Архивын ерөнхий
газар

ЛАВЛАХ
УТАС

1800-1205

ЦАХИМ
ШУУДАН



Манж Чин гүрний эрхшээлийн үед Сайн ноён аймгийн “Халхын умард замын дундад дахь өмнөд хошуу” нэртэйгээр байжээ.

“Сутай илдэн. Халхын аймгийн хүн. Түмэнхэний дүү Баарай хошуучийн жич. Энх амгалангийн 30 дугаар /1691/ онд Долоннуурт ирэхэд Зарлигаар засаг, Улсын түшээ гүн өргөмжилж, тамга шагнажээ хэмээжээ1.

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглахад тус хошууны засаг ноён Дондовжанцанд үе улиран Илдэн засаг цол хүртээж тамга шагнасан тул тус хошууг Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошуу хэмээн нэрлэх болов.

1. Халхын сайн ноён аймгийн ноёд, хутагт, хувилгаадын уг эх. Улаанбаатар хот. 2023 он.76 тал



Ардын хувьсгал ялснаас хойш МУ-д засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд хэд хэдэн томоохон өөрчлөлт шинэчлэлт хийсэн билээ. Ардын ЗГ-аас 1923 онд “МУ-ын нутгийн захиргааны дүрэм”-ийг батлан гаргав. Дээрх дүрмийг баримтлан аймаг, хошуу, сумыг шинэчлэн зохион байгуулах их ажлыг 1923-1925 онд амжилттай хэрэгжүүлсэн. Энэ дүрмэнд сум, хошуунд хүүхэд багачуудыг бичиг үсэгт сургах гэрийн сургуулиуд байгуулахыг заасан байдаг. Үүнийг цөөнгүй аймаг хошуу хэрэгжүүлсэн байна.

ОӨ-ний 13 /1923/ он 9-р сарын 10-ны өдрийн Ардын Засгийн газрын 38-р хурлын 1-р зүйлд хэлэлцээд: “Богдхан уулын, Ханхэнтий уулын, Хантайшир уулын, Цэцэрлэг мандал уулын аймаг” гэж шинээр байгуулсан аймгуудын уламжлалт нэрийг өөрчлөн уул усны нэрийг хэрэглэх болсныг тодорхой дурдсан байна. Аймаг, хошууны нэрийг өөрчлөх энэхүү түүхэн баримт нь Үндэсний Төв Архивын Х-1. Д-1. ХН-247 тоот дансны 10-р нэгжид хадгалагдаж буй билээ.



Ингээд 1691 оноос 1923 он хүртэл нэрлэж байсан хуучин нэр болох Сэцэн хан аймгийг Ханхэнтий уулын аймаг, Түшээт хан аймгийг Богд хан уулын, Засагт хан аймгийг Хантайшир уулын, Сайн ноён хан аймгийг Цэцэрлэг мандал аймаг хэмээн нэрлэж эхэлжээ. Мөн үүний зэрэгцээ хошуу, сум, отгийн хуучин нэрийг халж уул, усны нэрээр нэрлэх үйл ажиллагаа 1923 оны эцэс 1924 онд давхар явагдсан байна¹. Тухайлбал “Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошууг - Цэцэрлэг мандлын аймгийн Өлзийт уулын хошуу гэх зэргээр тухайн хошуу, суманд нь байгаа уул усны нэрээр нэрлэв.

1.Д.Мөнх-Очир-“Монгол улсын аймаг хошуу, сум, отог” УБ хот. 2019 он. 6-р тал

ӨЛЗИЙТ УУЛЫН ХОШУУ

“Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”-ийн дагуу 10 гэрээр арван, 50 гэрээр баг, 150 өрхөөр сум болгон шинэ захиргааг зохиоход 1924 онд Өлзийт уулын хошуу нь тооллогод Сант, Дэлгэрэх, Авдран, Ханги, Өндөр, Сангийн далай, Цагаангол, Ширээчулуу, Ёсөнзүйл, Өлзийт, Оргих, Жаргалант гэх 12 сумтай байжээ.

1925 оноос 1927 оны хооронд 1-4 сумтай хошуудыг татан буулгаж зэргэлдээ хошуудад нь нэгтгэх ажиллагаа явагдсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд 12 сумтай Өлзийт уулын хошуу хамрагдаагүй бөгөөд 1925 онд зэргэлдээх Дөлгөөн уулын хошуу нэмэгдэн орж

1926 онд Өлзийт уулын хошуу нь тооллогод дээрх дүрмийн дагуу арван, багийг байгуулж, Сант, Дэлгэрэх, Авдран, Ханги, Өндөр, Сангийн далай, Цагаан, Ширээчулуу, Ёсөнзүйл, Өлзий, Оргих, Жаргалант, Гүндсамба сум, Лагшин сум, Төгс уул сум гэх оноосон нэртэй 15 сумтай байжээ.

1928 онд хуралдсан V их хурал нь 150 өрх бүхий сумын зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж 300 өрхөөр нэг сум болгон зохион байгуулах шийдвэр гаргасны дараа буюу

1929 онд “Авдран, Дэлгэрэх, Өлзий, Есөнзүйл, Жаргалант, Оргих-Өндөр, Сант, Сангийн далай, Цагаан, Ширээ чулуу” гэсэн 10 сумтай болжээ.

1922-1928 оны хооронд байсан сумуудыг 300 өрхөөр нэгэн сум болгон өөрчилж хоёр сумыг нэгтгэн нэг сум болгохдоо нэг сумынх нь нэрийг өгөх эсвэл хоёр сумын нэрийг нийлүүлэн нэрлэж байсны зэрэгцээ тус сумуудын нэрнээс огт өөр нэр өгч байсан тохиолдол цөөнгүй байна. Тиймээс өнөөгийн зарим сум нь АЗ-ийн үеийн баримтанд 2, 3 өөр нэрээр тэмдэглэгдсэн тохиолдол нилээдгүй бий.

Тус хошууны хүн амын тооллогын баримтын уг эхийн тухай цухас өгүүлбээс.

ҮТА-ын сан хөмрөгт Өлзийт уулын хошууны баримт нь Х-152 дугаарт 1922, 1924, 1925, 1926, 1927, 1929 оны хүн амын тооллогын баримт байна.

Баримтыг Илдэн засгийн хошууны сүүлийн ноён Норовжанцангийнхаар харуулбал доорх мэт:

1922 оны тооллогын баримт

ҮТА-ын сан хөмрөгийн Х-152. Д-1. ХН-6 “Өргөх цэс” гэх баримтад өрх ам, мал сүргийг бүртгэн хүмүүсийг ноён, тайж, лам, хар, чавганц, бэр, хүргэн гэх зэргээр дэлгэрэнгүй бүртгэхээс гадна хошуунд байсан хүрээ хийдийн жасын хөрөнгийн бүртгэсэн байна.

1922.11.11

Тус баримтын эхэнд Сайн ноён хан аймгийн жүн вангийн зэрэг Илдэн засаг төрийн бэйл Норовжанцангийн хошууны бүх хүн амыг магадлан байцаан тодорхойлсон нь:

	нас	өрх	Ам
Илдэн ван Норовжанцан	12	1	4
Эх хатан Цэрэндолгор	36		
Дүү хуварга Цэрэндүн	11		
Охин дүү Дэнсмаа	9		
Ноёны малыг 19 хүн маллаж байна.			
Адуу		964	
Тэмээ		80	
Хонь, ямаа		5494	
Үхэр		68	

ᠠᠷᠬᠢᠪᠢᠨ ᠶᠡᠷᠦᠨᠬᠢᠢ
ᠭᠠᠰᠠᠷ

1925 оны баримт

ҮТА-ын Х-152. Д-2. ХН-4 “Өлзийт уулын хошууны хүн амын өргөх данс” гэх 264 хуудастай баримтын Нэгдүгээр сум Сант сумын нэгдүгээр багийн 3-р өрхөд Норовжанцан ноёныхон байна. Тооллогонд лам нарын нас, бусад эрчүүдийн насны бүлгийг 4 хувааж 1-7, 8-17, 18-45, 46 наснаас дээш, бичиг үсэг, гэрийн ажил, өвчин эмгэгтэй эсэхийг бүртгэжээ.

№	НЭР	Нас	бичиг	Юу хийдэг	Өвчин эмгэг
3	Норовжанцан	15	Монгол бичиг	Бичгийн ажил	
	Дүү Цэрэндун	14			
	Эх Цэрэндолгор	39			
	Дүү Дэнсмаа	11			
Монгол Улсын 15 /1925/ он 9 сарын 20					